



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

**БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВ**
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Нарны зам 87 дугаар байр, 13 дугаар хороолол,
1 дүгээр хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14230
Утас: 7577 2727, Цахим шуудан: info@edu.mn,
Цахим хуудас: www.itc.edu.mn

2024.05.14 № 1/231
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргэх тухай

Тус төвийн зарласан БМТТ/20240103003 дугаартай, "Ахлах ангийн сонгон судлах хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах үйлчилгээ" үзүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулга авах тухай хүсэлтийг хүлээн авч танилцаад дараах хариуг хүргэж байна. Үүнд:

1. "Төлбөр төлөх товч энэхүү тендерийн хувьд идэвхжээгүй байна." Гэсэн асуудлын хувьд Төрийн худалдан авах ажиллагааны газрын мэдээллийн технологийн хэлтэст үнэлгээний хорооны дарга биечлэн уулзаж шалтгааныг тодруулахад "Тендерийг анх зарлахдаа "уламжлалт" гэсэн төрлийг сонгож зарласан бол төлбөр төлөх товч идэвхжихгүй, бусад тохиолдолд тийм асуудал гарах ёсгүй гэсэн тайлбар өгсөн. Мөн тус тендерийн урилгын дугаараар ТХАГ-ын ажилтан өөрөө нэвтрэн орж шалгаж үзээд төлбөр төлөх товч идэвхжиж байна, танай тендер "хялбаршуулсан-цахим" төрлийг сонгож НТШ зарласан тул ямар нэг асуудалгүй байна. Гэсэн хариуг өгсөн.
2. "Өмнө энэхүү тендер оролцогч үндсэндээ бүгд тэнцүү буюу хасагдсан гэж тайлбар авсан." Гэсэн асуудлын хувьд багц тус бүрд оролцогч нарт ямар үндэслэлээр хасагдсан талаар тайлбарыг албан бичгээр мэдэгдсэн болно.
3. "Бүгд хасагдсан, мөн багцын үнэ дахин зарлагдахтай 2 дахин буурсан. Эдгээр гурван хувьсагч хоорондоо холбоотой юу?" гэсэн асуудлын хувьд тендер шалгаруулалт амжилтгүй болсон хугацаанд ногдох зардлыг бууруулан тооцоолж, төсвийн ерөнхийлөн захирагч болох Боловсрол, шинжлэх ухааны яамны зөвшөөрлөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол оруулж батлуулсны дагуу төсөвт өртгийг шинэчлэн баталж, тендер шалгаруулалтыг зарласан болно.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЭНХБАТ